

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ДЭРГЭДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Энэхүү хорооны үндсэн зорилго нь

- 1.1 Салбарын ҮЭ-ийн үйл ажиллагаанд ардчилалыг хөгжүүлэх, удирдах болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог өргөжүүлэх, эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгааллын талаар явуулах Салбарын ҮЭ-ийн холбооны бодлого, зохион байгуулах арга хэмжээний саналыг боловсруулж хэрэгжүүлэх, сургалт, олон нийтийг хамарсан компани ажлыг зохион байгуулах, Олон улсын байгууллагын бодлого шийдвэрийг ҮЭ-ийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд оршино.
- 1.2 Эмэгтэйчүүдийн хороо нь Монгол улсын хууль, МҮЭ-ийн холбооны дүрэм, Салбарын ҮЭ-ийн хорооны дүрэм болон энэхүү журмын хүрээнд үйл ажиллагаа явуулна.

Хоёр. Бүтэц бүрэлдэхүүн

- 2.1 Эмэгтэйчүүдийн хороо нь Салбарын ҮЭ-ийн холбооны гишүүн эмэгтэйчүүд болон ҮЭ-ийн хороодын эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан тэргүүлэгчдээс бүрдэнэ.
- 2.2 Эмэгтэйчүүдийн хороо нь Тэргүүлэгчтэй байх бөгөөд түүнийг хорооны хурлаас сонгоно.
- 2.3 Тэргүүлэгч нь эмэгтэйчүүдийн хорооны үйл ажиллагааг хорооны гишүүдийн хурлын хооронд эрхлэн явуулна.
- 2.4 Эмэгтэйчүүдийн хороог байгуулах, татан буулгах тэдгээрт өөрчлөлт оруулах асуудлыг тэргүүлэгчдийн хурлаараа шийдвэрлэнэ.

Гурав. Хорооны эрх үүрэг

- 3.1 Хороо нь дор дурьдсан эрхийг хэрэгжүүлнэ.
 - 3.1.1 Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаар ҮЭ-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, энэ талаар бодлого боловсруулахад оролцох
 - 3.1.2 Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчийн хуралд асуудал оруулж шийдвэрлүүлэх
 - 3.1.3 Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны ажлын төлөвлөгөөнд асуудал тусгах, эрхэлсэн ажлаараа ҮЭ-ийн хороодтой болон орон нутгийн эмэгтэйчүүдийн болон бусад төр олон нийтийн байгууллагатай хамтарсан үйл ажиллагаа явуулах
 - 3.1.4 Эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрх түүнтэй холбогдсон асуудлаар ҮЭ-ийн гишүүд эмэгтэйчүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах
- 3.2 Эмэгтэйчүүдийн хороо нь дор дурьдсан үүрэгтэй байна.
 - 3.2.1 Эмэгтэйчүүдийн талаарх Салбарын ҮЭ-ийн холбооны бодлого, баримтлал, төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэвлэл мэдээлэлээр сурталчилах
 - 3.2.2 Эмэгтэйчүүдийн нийгмийн баталгааг хангах, тэдний эрх, нийтлэг ашиг сонирхолыг хөндсөн асуудлаар судалгаа дүгнэлт гаргах, төр засаг, ажил олгогчдод санал шаардлага тавих
 - 3.2.3 Эмэгтэйчүүдэд зориулсан амьдрах арга ухаан, хууль, эрх зүйн сургалт, дамжаа зохион байгуулах
 - 3.2.4 ҮЭ-ийн бүх шатны байгууллагын сонгуульд тэднийг бэлтгэх

3.2.5 Удирдах ажилд ҮЭ-ийн эмэгтэй гишүүдийн нэрийг дэвшүүлэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

Дөрөв Эмэгтэйчүүдийн хорооны ажиллах журам

- 4.1 Эмэгтэйчүүдийн хороо нь шаарлагатай үед хуралдаж хэлэлцсэн асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж, тэмдэглэл гаргаж зөвлөлийн хуралдаан, тэргүүлэгчдийн хурал, дарга нарын зөвөлгөөнд оруулна.
- 4.2 Эмэгтэйчүүдийн хорооны дарга орлогч даргыг хорооны хурлаас сонгоно.
- 4.3 Эмэгтэйчүүдийн хорооны дотоод ажил хариуцсан нарийн бичгийн даргатай байх ба энэ үүргийг Салбарын ҮЭ-ийн холбооны зохион байгуулагч гүйцэтгэнэ.
- 4.4 Эмэгтэйчүүдийн хорооны үйл ажиллагаа явуулах зардлыг Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны төсөвт тусгана.
- 4.5 Эмэгтэйчүүдийн хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ

---oO---